



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/18

Хэрлэн сум

Бага насны хүүхдийн цогц хөгжлийг  
дэмжих ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.11 дэх заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын А/236, А/189, А/80 дугаар хамтарсан тушаалын дагуу тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Салбар дундын хамтын ажиллагааг орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, үйл ажиллагааг дэмжин ажиллах чиг үүрэг бүхий Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон тооны бус зөвлөлийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн  
дарга:

Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн  
дарга:

Боловсрол, шинжлэх ухааны газрын Сургуулийн өмнөх  
боловсрол хариуцсан мэргэжилтэн

Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн ам зүйн, нийгмийн  
хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, гэр бүл, хүүхэд  
залуучуудын бодлого хариуцсан мэргэжилтэн

Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсролын бодлого  
хариуцсан мэргэжилтэн

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга

Эрүүл мэндийн газрын дарга


Боловсрол, шинжлэх ухаан газрын дарга

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн  
хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Эх нярайн тусламж үйлчилгээ  
хариуцсан мэргэжилтэн

2.Ажлын хэсгийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан шаардагч зардлыг орон нутгийн жил бүрийн төсөвт тусган шийдвэрлүүлж ажиллахыг Ажлын хэсгийн даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

D:\My Documents\ Захирамж-2024